



Д.ТӨГСБАЯР
*ШШГЕГ-ын Тогтоол
 гүйцэтгэх газрын
 Нэгдсэн тоо бүртгэл,
 судалгаа, дүн
 шинжилгээний тасгийн
 дарга, ахмад*

ЯЛТАНД ОЛГОХ УРАМШУУЛЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

VII-IX зуунд хүчирхэгжин мандаж байсан байсан Кидан улсын үед ялт хүнийг газар, гянданд хийж хорьдог байсан тухай доктор Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нар өөрсдийн бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. Гэвч өнөөгийн хорих ялтай дүйцүүлэн ойлгох араггүй. 1921 оноос өмнөх үеийн шорон, гянданг өнөөгийн цагдан хорих байртай адилтгаж, нүүдлийн соёл иргэншлийн онцлогоос шалтгаалан хорих ялын тухай ойлголт Монгол улсад харьцангуй сүүлд үүссэн гэж үзэж болох талтай.

1921 оны 8 дугаар сард Шүүх явдлын яамнаас Богд эзэн гэгээнтэнд өргөн барьсан "Эрүү шүүлтийг болгоомжлон цагийг дагаж хувьсган тогтоох тухай айлтгал" бичигт ташуур жанчих, дөнгө дөнгөлөх, цөлөх, алах дөрвөн эрүү /ял/ байгааг дурьдаад засгаас урвах, цэргийн цаазад холбогдох эрүү /ял/-г хэвээр үлдээж бусад олон зүйлийн алах ялыг хөнгөтгөн, алах ялыг 7-10 жил, цөлөх ялыг 1 жилээр үйлдэх ял оноож, жил хугацааны дотор гянданд хорьсоор, өдөр бүр зүдгүүртэй ажил хийлгэх ба

дөнгө дөнгөлөхийг уг өдрийн тоогоор, ташуур жанчихыг нь 5 ташуур тутам нэг өдрийн үйлдэх ял оноож, нэгэн адил баримтлан захирч хатуу ажилд зүтгүүлсүгэй гээд пүнлүү хасах, золио авах ялыг малаар торгох ялд таацуулан, аливаа нэгэн зүйлийн ял хэлэлцэхэд тайж, ард хэмээн ялгаварлахгүй байх тухай тусгасан байна. Ингэж 1921 оноос эхлэн Монгол улсад хорих ялыг жинхэнэ утгаар нь хэрэглэх эрх зүйн үндэс бүрдсэн хэмээн үзэж болохоор байна.

1924 онд Монгол улсын анхдугаар их хурлаар Монгол улсын анхны Үндсэн хууль батлагдаж, 1925 оны 2-р их хурлаас Үндсэн хуульд нийцүүлэн бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгоор "Шүүн таслах эрхийг шинэтгэн явуулах тухай" тогтоол гаргаж, Эрүүгийн эрх зүйн үндсэн зорилт зарчмыг тодорхойлохдоо "Хэрэгтэн хэргийг шийтгэх ял, улс төрийн бодлого бол хэрэгтнийг сурган хүмүүжүүлэхийг гол болгох, оногдуулах ял нь хууль зүйд нийцсэн, хэрэгтэн этгээдэд засрах бололцоо олгосон хөдөлмөр хийлгэх, цаг хугацаа дуусахын өмнө тэнсэн суллах зэргийг оролцуулсан байвал зохино" гэж заажээ.

Хорих ял эдлэгсдийн хүмүүжил, сурлагын түвшин, хөдөлмөрийн амжилтыг үнэлж зохих урамшуулал үзүүлэх асуудал бүр 1929 оноос эхтэй байжээ. Хорих ял эдлэгсдийн хөдөлмөр бүтээлийг үнэлж ажлын хоног олгон, өөрөөр хэлбэл сайн ажилласан 1 өдрийг 2-т тооцон тэр хэмжээгээр эдлэх ялаас нь хасч тооцох уламжлал одоо хүртэл

ялтанд шагналын хоног олгох урамшууллын хэлбэрээр үргэлжилсээр байна.

1930 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын 24 дүгээр хурлын 3 дугаар зүйл ба мөн 8 дугаар сарын 24-ний өдрийн хуралдсан бага хурлын тэргүүлэгчдийн 25 дугаар хурлын 1 дүгээр зүйлд тус тус батлагдсан хянан харгалзах комиссын ажил явуулахын дүрэм батлагджээ. Энэ дүрмийн 1 дүгээр зүйлд заахдаа хянах комисс нь ялтныг хорих газрын дэргэд байгуулах бөгөөд орон нутгийн шүүх таслах газруудаас байгуулах, Улаанбаатар хотод бол Төв засан сайжруулах газрын дэргэд хянан харгалзах комиссыг шүүх яамнаас байгуулна гэж заажээ.⁴²

Хянан харгалзах комиссын хурлыг 2 долоо хоногт 1-ээс цөөнгүй удаа хуралдуулж байхаар зааж, уг комиссуудын гүйцэтгэх үүрэгт хоригдолд олгох урамшууллыг хэлэлцэх асуудал багтаж байсан байна. Үүнд:

- Ажлын хоног олгох ба түр чөлөө олгох
- Ялын хугацаанаас өмнө онцын шалтгаанаар бүр мөсөн чөлөөлөгдөх туха асуудлыг шийдвэрлэх. Дүрмын 9 дүгээр зүйл

1. 1931 онд хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан Монгол улсын анхны хууль буюу "Монгол Ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль"-ийг

Улсын Бага Хурлын 12 дугаар хуралдаанаар баталсан нь эрүүгийн ял эдлүүлэх байгууллагын түүхэнд томоохон үйл явдал болжээ. Энэ хуулиар анх удаа засан сайжруулах газруудын бүтцийг тогтоож, түүнийг төрөлжүүлэн хуваасан байна. Уг хуулийн агуулга, түүхэн ач холбогдлын талаар Хууль зүйн ухааны доктор, профессор, Монгол Улсын гавьяат хуульч А.Лхагва өөрийн зохиол, бүтээлдээ дэлгэрэнгүй дурдсан байдаг.

Уг хуулинд анх ял эдлэгсдэд олгох сайшаал урамшилыг онц сонирхолтой хэлбэрээр тусгаж өгсөн байдаг

Энэ хуульд хорих ял эдлэгсдэд үзүүлэх урамшлын талаар тусгайлан заагаагүй боловч хөдөлмөрийн үр дүнг хөхүүлэн дэмжиж ажлын хоног олгох, /14/, хөдөлмөрийн хөлс олгох, гаднаас хоол хүнс эргэлт авах эрх олгох /49/, ял эдлэх явцдаа алдсан хүчнийг нь сэргээх, хүнлэг хандах үүднээс 7-14 хоногийн чөлөө олгож байсан /55/ зэргээр урамшуулан шагнаж байсныг хоригдогсодын урамшууллын олголтод хамааруулан үзэж болох юм.

Тухайлбал: Жинхэнэ ажлын хүмүүст нэг жил ял эдэлсний дараа 7 хоног, хоёр жилийн дараа 14 хоногийн, бусад ангийн хүмүүс ба хүнд гэмт хэрэг үйлсэн хүмүүст 1 жил 6 сар ял эдэлсэний дараа 7 хоног, гурав ба түүнээс жил ял эдэлсэний дараа 14 хоногийн чөлөө тус тус олгохоор заасан.

Мөн зүйлд "Хоригдогсодын дотор буй жинхэнэ ажлын ардуудаас ажилд онц хичээлтэй бөгөөд уул ажлын дадлагыг олсон тухайд харьяат хянан харгалзах комиссын тогтоолоор ажил хийсэн 2 өдрийг хорих буюу хорихгүйгээр албадан ажил хийх хугацаанд 3 өдөрт тооцож урамшуулбаас

⁴² Б. Дашзэвэг "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн сурган хүмүүжүүлэх зүй" УБ. 1976, 40 дэх тал.

зохимой” хэмээн заасан нь одоо хүртэл эрх зүйн түүхэн уламжлал болон хоригдолд ажлын хоног олгох хэлбэрээр хэрэглэгдсээр байна.

Ял эдлэгсэдийг хөдөлмөрийн хөлсний 25 –аас доошгүй хувийг өөрсдөд нь, мөн 25 хувийг улсын санд оруулах болон ашиг хувиарлах журмыг хуулийн тодорхой заасан /30/

Аливаа хэрэгтэн ялтанд шагнал урамшил олгохдоо хоригдогсдын ангийн болон үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, хөрөнгө чинээний байдлыг харгалзан үзэж ялгавартайгаар шагнаж урамшуулдаг байсан байна. Тухайлбал: Хуульд тусгайлан заасан /55/ нэг зүйл бол ял эдлэгсдэд хянан хянан харгалзах комиссын тогтоолоор чөлөө олгох асуудал юм. Ял эдлэгсдэд чөлөө олгохдоо: а. Жинхэнэ ажлын ангийн хүмүүс б. Бусад ангийн хүмүүс ба хүнд гэмт хэрэг үйлдсэн хүмүүс гэж ялгавартай хандаж байсан. А-д заасан хүмүүст нэг жил ял эдэлсэний дараа 7 хоног, хоёр жилий дараа 14 хоног, Б-д заасан хүмүүст 1 жил 6 сар ял эдэлсэний дараа 7 хоног, гурав ба түүнээс дээш жил ял эдэлсэний дараа 14 хоногийн чөлөө тус тус олгож байжээ.⁴³

2. Ардын сайд нарын зөвлөлийн 1950 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн “БНМАУ-ын дотоод явдлын яамны засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерь, гянданд хоригдлыг байлгах тухай дүрэм”-ийг батлах тухай 126 дугаар тогтоол гарч Монгол Ард улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль”-ийг халж түүнийг орлон үйлчлэхүйц хуулийн хэмжээний эрхний акт болж үйлжилж

байсан. Дүрмэнд ялтанд олгох урамшууллын талаар дараах байдлаар тусгаж өгсөн.

Дотоож журмыг сайтар сахин хэрэгжүүлсэн, үйлдвэрлэлийн нормоо давуулан биелүүлсэн хоригдолд доорх төрлийн урамшуулал үзүүлэхээр заажээ. Үүнд:

а. Өөрт болон нийтийн өмнө тушаалаар баяр хүргэж хувийн хэрэгт нь тэмдэглэх

б. Мөнгө болон эд зүйлээр шагнах

в. Хугацаанаас өмнө уулзалт хийхийг зөвшөөрөх

г. Ялын гуравны нэг хувийг эдэлсэн бол чанга дэглэмээс жирд шилжүүлэх

д. Ялынхаа гуравны нэгийг эдэлсэн жирийн дэглэмийн хоригдолын ялын үлдсэн хугацааг хасах, тэнсэн суллах тухай тодорхойлолт гаргах, жил тутам арав хоног ажлаас чөлөөлж лагерь, колонны зонны байранд амраах, үйлдвэр техникийн бага, дунд тушаалын албанд ажиллуулах боломж олгох.

Мөн хөдөлмөрийн тэргүүний арга туршлага эзэмшин үр бүтээлтэй ажиллаж байгаа хоригдолд дараах нэмэгдэл урамшуулал үзүүлдэг байжээ.

а. Байрын нөхцлийг сайжруулах

б. эхний ээлжинд тусгайлан зассан ширээнд суулган хоолоор үйлчлэх

в. Хоолны чанарыг сайжруулах

г. Дэлгүүр, мухлагаар эхний ээлжинд үйлчлэх

д. Лагерь, колонны номын сангаас дараалал харгалзахгүйгээр ном, сонин, сэтгүүл олгох.

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн лагерь-колонийг удирдах газрын дарга, орлогчид хоригдолд бүх төрлийн урамшлыг, бусад шатны дарга нар зарим хэсгийг үзүүлэх зэрэг заагтай эрх эдэлдэг байжээ.

⁴³ А.Лхагва “Монгол улсын эрүү, иргэний хэрэгт холбогдох шүүхийн шийдвэрийг биелүүлэх хууль тогтоомжийн хөгжилт” /1931-2005/ УБ. 2005, 12 дахь тал.

Мөн үлгэр жишээ сайн оролцдог хоригдлуудад өөрсдийнх нь хүсэлтээр халуун хоол, зууш, цай үнээр нь худалдахыг /өдөр, оройн хоолны дараах чөлөөт цагт/ зөвшөөрсөн явдал урамшууллын чухал ач холбогдолтой байжээ.

3. БНМАУ-ын Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 1966 он 03-р сарын 24-ны өдрийн 50-р зарлигаар Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль нууцын зэрэглэлтэйгээр батлагдсан нь Монгол улсын эрүүгийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтанд түүхэн үе нээсэн чухал үйл явдал болсон юм.

Хуулийн 20 дугаар зүйлд үлгэр жишээчээр хүмүүжиж, төлөв төлөв томоотой, хөдөлмөр сургалтанд үнэнчээр хандсан хоригдлуудад гяндан, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колоны захиргаанаас дараах урамшууллын арга хэмжээг хэрэглэнэ.

- Баяр хүргэх
- Үлдвэрлэлийн сайчуудын самбарт зургийг тавих.
- Баярын бичиг үнэ бүхий зүйлээр шагнах
- Захиргаанаас оногдуулсан сахилга батын арга хэмжээг хугацаанаас өмнө арилгах.
- Нэмэгдэл илгээлт буюу эргэлт авах
- Гадаалах хугацааг нэмэгдүүлэх
- Ээлжит уулзалтаас гадуур төрөл, садантайгаа уулзах
- Хүнсний болон нэн хэрэгцээний зүйлийг тогтоосон хэмжээнээс илүү худалдан авахыг зөвшөөрөх

Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комисстой зөвшөөрөлцөн, энэ хуулийн 33 дугаар зүйлд зааснаар колоны захиргааны шийдвэрээр насанд хүрээгүй хүмүүсийн хоригдож байгаа нөхцлийг урамшууллын журмаар өөрчилж болно. Мөн зүйлд үлгэр жишээчээр засран хүмүүжиж,

хөдөлмөрт үнэнч шударгаар хандаж байгаа тохиолдолд сард 1 удаа түр буюу хамт байх эрхтэйгээр уулзахын аль нэгийг, мөн эргэлт илгээлт авахыг сард 1 удаа нэмж зөвшөөрч болно гэж зааж өгсөн байдаг.

Хоригдолын хөдөлмөрийн үр дүнг хөхүүлэн дэмжиж ажлын хоног олгодог байсан өмнөх хуулийн заалт тус хуульд тусгагдаагүй орхигдсон ба БНМАУ-ын СнЗ-ийн 1950 оны 287 тоот тогтоолын хоригдолд шагналын хоног олгож, эдэлсэн ялд нь оруулан тооцох тухай заалт үргэлжлэн хэрэгжиж ирсэн байна.

4. БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдийн 1981 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 43 дугаар зарлигаар “БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль” батлагдан гарч, 1982 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс мөрдөгдөж эхлэв. Энэ нь Монгол Улсын эрүүгийн ял эдлэх, эдлүүлэх ажиллагааг зохицуулах 3 дэхь хууль байлаа.

Хуулийн 8 дугаар бүлэг 49 дүгээр зүйлд Хорих ял эдэлж байгаа ялтны урамшуулал олгох талаар тусгаж өгсөн. Үүнд:

Зан төлөвөөр сайн, хөдөлмөр, сургалтанд үнэнч шударга ханддаг, улс төр хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцдог, хорих дэглэмийн шаардлагийг нарийн чанд биелүүлдэг, боловсрол мэргэжлээ дээшлүүлэхийг эрмэлзэн засарч, хүмүүжиж байгаа ялтанд дор дурдсан урамшил үзүүлнэ.

- Баяр хүргэх
- Тэргүүний хүмүүсийн зургийг самбарт тавих
- Сайшаалын үнэмлэх олгох
- Бүтээлийн нормоо давуулан биелүүлж, гарамгай амжилт гаргасан тохиолдолд хөдөлмөрийн нөхцөлийг харгалзан БНМАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах

Яамнаас тогтоосон журмын дагуу ажлын хоног олгох.

- Мөнгөн шагнал олгох
- Жилд хоёр удаа хүртэл нэмэгдэл эргэлт буюу илгээлт оруулахыг зөвшөөрөх
- Жилд хоёр удаа хүртэл түр, нэг удаа удаан хугацаагаар нэмэгдэл уулзалт хийхийг зөвшөөрөх.
- Баяр ёслолын өдөр хүнсний болон нэн тэргүүний хэрэгцээт зүйлийг худалдан авахад зориулж 10 хүртэл төгрөг нэмж зөрцуулахыг зөвшөөрөх.
- Хүмүүжил хөдөлмөрийн колонид ял эдэлж байгаа ялтанд сард 10 төгрөг нэмж зарцуулахыг зөвшөөрөх.
- Урьд оногдуулсан сахилгын арга хэмжээг хугацаанаас нь өмнө арилгах.
- Гадаалах хугацааг жирийн дэглэмтэй гяндан ял эдэлж байгаа ялтанд 2 хүртэл цагаар, чанга дэглэмтэй гянданд ял эдэлж байгаа ялтанд 1 хүртэл цагаар нэмэгдүүлэх.

Засрах замд баттай орж байгаа ялтны цаашид ял эдлэх дэглэмийг БНМАУ-ын хууль тогтоом жид заасан журмын дагуу.

- Гянданд эдлэх ялын тал хувиас доошгүйг эдэлсэн бол онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид шилжүүлэх.
- Онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлэх ялын тал хувиас доошгүйг эдэлсэн бол чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид шилжүүлэх.
- Чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид эдлэх ялын тал хувиас доошгүйг эдэлсэн бол жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонид шилжүүлэх.

Үлгэр жишээч шударга баттай, хөдөлмөр сургалтанд үнэнч хандаж засар

хүмүүжсэнээ нотлон харуулсан ялтныг хуулиар тогтоосон журмын дагуу хугацаанаас нь өмнө суллах, тэнсэж суулах буюу үлдсэн ялыг өөр хөнгөн ялаар сольж болно.

Мөн хуулийн 50 дугаар зүйлд Хорих ял эдэлж байгаа ялтныг урамшуулах журмыг зааж өгсөн байдаг. Үүнд.

- Мөнгөн шагналыг ялтны нэрийн дансанд хийнэ. Нэмэгдэл эргэлт, илгээлт авах урамшлыг энэ хууль зааснаар эргэлт, илтгээлт авах эрхтэй ялтанд үзүүлнэ.
- Жирийн дэглэмтэй гянданд ял эдэлж байгаа ялтанд зөвхөн түр уулзалт хийх урамшилыг үзүүлнэ.
- Гянданд ял эдэлж байгаа ялтанд гадаалах цагийг нэмэгдүүлэх урамшлыг нэг сараас илүүгүй хугацаагаар үзүүлнэ.
- Ялтны сахилгын арга хэмжээг урамшлын журмаар хугацаанаас өмнө арилгахдаа нэг удаад нэг арга хэмжээг урилгаж болно.
- Сахилгын арга хэмжээг хугацаанаас өмнө арилгах болон баяр хүргэх урамшлыг амаар буюу бичгээр, бусад урамшлыг зөвхөн бичгээр хэрэглэнэ гэж зааж өгсөн байдаг.

Уг хуулинд дээрх олон төрлийн урамшил үзүүлэх зарчмын шинэ заалтууд орсон нь ялнты урмыг сэргээсэн чухал арга хэмжээ болсоноос гадна Ялтанд ажлын хоног олгох асуудлыг ингэж хуульчлан баталснаар урьд нь бараг ял завшуулах нэг хэлбэр мэтээр үздэг байсан ойлголтыг арилгахад чухал нөлөөлсөн.

БНМАУ-ын НАХЯ, Улсын прокурорын 1983 оны 6-р сарын 14-ний “Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын дотоод дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 525/148 тоот тушаалд нэг ялтанд жилд олгох ажлын хоногийн тоо 150-аас хэтэрч болохгүй тухай

заасан нь уг асуудын эрх зүйн зохицуулалтыг бүр ч тодорхой болгож, хэрэгжих магадлалыг нэмэгдүүлжээ.

5. 1993 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай МУ-ын хууль батлагдан гарсан ба хорих ял эдэлж байгаа хоригдолд олгох урамшууллыг дараах хэлбэрээр тусгаж өгсөн байдаг.

Хорих ангийн дэглэм журмыг чанд сахиж, хөдөлмөрлөх үүргээ амжилттай сайн биелүүлж байгаа хоригдлыг Хорих ангийн шийдвэрээр дараах хэлбэрээр сайшааж урамшуулна:

1. Баяр хүргэх, сайшаалын үнэмлэх олгох
2. Хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх
3. Урьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах
4. Төрөл садантайгаа уулзах уулзалт болон гэднээс авах илгээмжийн тоог нэмэх.
5. Энэ хууль заасны дагуу шагналын хоног олгох

Ялын талаас доошгүйг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй, хөдөлмөрийн үүргээ амжилттай биелүүлж сайшаагдаж байсан хоригдлын ял эдэлж байгаа дэглэмыг бууруулах тухай шүүхэд тодорхойлох. Энэ заалт нь онц аюултай гэмт хэрэгтэн, онц хүнд гэмт хэрэгт шийтгүүлсэн болон санаатай гэмт хэрэгт удаа дараа хорих ял шийтгүүлж байсан этгээдэд хамаарахгүй гэж зааж өгсөн.

6. Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хууль нь удаан үйлчлээгүй ба 1996 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль батлагдсан.

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулинд хоригдолд олгох шагнал, урамшилыг заримыг Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай 1993 оны

хуулинд заасантай адил зааж өгсөн ба хоригдолд шагналын хоног олгох асуудлыг саашаал урамшууллын төрөлд оруулж өгөөгүй хуулийн 75-р зүйлд хорих ангийн албан хаагчийн эрхийн нэг болгон тусгасан.

Оногдсон ажлаа чанартай сайн гүйцэтгэсэн бөгөөд сахилгын зөрчил гаргаагүй хоригдолд улиралд 30 хүртэл шагналын хоног өгөхөөр заасан. /75:4:6/

Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын даргын 1999 оны 3-р сарын 22-ны өдрийн а/37 тоот тушаалаар “Хоригдолд шагналын хоног олгох буцааж хасах журам батлагдсан.

Хоригдолд шагналын хоног олгох нь Хорих ангийн дэглэмийн сахилга бэхжүүлэх хөшүүрэг мөн гэж заасан

Оногдсон ажлаа чанартай сайн гүйцэтгэсэн, сахилгын зөрчил гаргаагүй хоригдолд 1 улиралд өгч болох шагналын хоног олгоход албан тушаалтаны эдлэх эрх нь.:

1. Хорих ангийн дарга 10 хоног

2. Хорих ял эдлүүлэх газрын дарга 20 хоног

3. Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын дарга 30 хүртэл хоног гэж заасан

УИХ-аас 1998 онд батлагдсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2002 оны 01 дүгээр сарын 08-нд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль батлагдан гарсан. Монгол улсын эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын эхний ээлжинд хамаарагдах дээр дурьдсан хуулиудад үг үсгээс эхлээд, үзэл бодлын зөрөөтэй томьёолол, нэг нь нөгөөдөө харшилсан төдийгүй, эрх зүйн харилцаанд оролцогч субъектүүдийн эдлэх эрх, хүлээх үүрэг харилцан адилгүй тусгагдсан, зарим тохиолдолд хүний эрх, эрх чөлөөг элтээр зөрчсөн заалт олон байсан. Эдгээрийг хууль

тогтоогчид нэг мөр болгон жигдлэх, төрийн ялын бодлого, төрөлд ялын төрөлд зарим өөрчлөлт оруулах зорилт тавьж шийдвэрлэсэн юм.⁴⁴

7. Хуулийн 126 дугаар зүйлд ялтныг олгох урамшууллын талаар зааж өгсөн.

Хорих ангийн дэг журмыг чанд сахиж, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж байгаа ялтныг хорих ангийн даргын шийдвэрээр дараахь хэлбэрээр урамшуулна.

- хөдөлмөрийн нөхцлийг өөрчлөх;

- урьд оногдуулсан сахилгын шийтгэлийг хугацаанаас нь өмнө арилгах;

- энэ хуульд заасны дагуу шагналын хоног олгох.

Хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах, гянданд хорих ялыг хорих ангид эдлүүлэхээр буюу хорих ангид эдлэх ялыг гянданд хорих ялаар солих тухай санал гаргах

Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу ялтан оногдуулсан хорих ялын тодорхой хувийг эдэлсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлоо төлсөн бол түүнийг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах саналыг хорих ангийн дарга прокурорт гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Хорих ялын хоёрны нэгээс доошгүй хувийг эдэлсэн, сахилгын зөрчил гаргаж байгаагүй, хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж урамшуулагдаж байсан ялтны ял эдэлж буй дэглэмийг бууруулах тухай саналыг хорих ангийн дарга прокурорт

гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 335 дугаар зүйлд зааснаар гянданд хорих ялыг зохих дэглэмийн хорих ангид эдлүүлэхээр буюу хорих ангид эдлэх ялыг гянданд хорихоор солих тухай саналыг хорих ангийн дарга прокурорт гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

ДҮГНЭЛТ:

Ялтныг сайшаах урамшуулах нь бие хүнд сайхан сэтгэгдэл төрүүлэх, цаашдын амьдалдаа итгэлтэй болох, ялаа эдэлж дуусгах төлөвлөгөө гаргах, ялтны үйл ажиллагаа, зан төрхийн амжилт, сайн талыг идэвхижүүлэх, эсхүл зан байдлын доголдол зохисгүй зүй бус үйл ажиллагааг хоригдлох, бурууг ойлгуулан гэмшүүлж, ялтыг хүмүүжүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн зохицуулалт юм.

Ялтанд олгох урамшууллын эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлалыг судлан үзэхэд 6 удаагийн нэр бүхий хууль, дүрэмд тусгагдаж, ялтнуудыг шагнаж урамшуулж байсан уламжлалын зарим ололттой талыг одоогийн ял эдлүүлэх харилцаанд хэрэгжүүлж болох юм.

Тухайлбал:

1. Сайшаалын үнэмлэх олгох ("Тэргүүний хүмүүжигчийн урамшуулал тогтоох журмам"-ын дагуу Тэргүүний хүмүүжигч тэмдэг, Тэргүүний хүмүүжигч гэрчилгээ олгож байгаа)
2. Мөнгөн шагнал олгох
3. Хугацаанаас өмнө уулзалт хийхийг зөвшөөрөх

Санал:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 126-р зүйлийн 126.1-т заасан

⁴⁴ А.Лхагва Монгол улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй. УБ. 2004 он, 60 дахь тал